



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 1140

Мандалговь

“Баянцогт зам” ХХК-тай гэрээ  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, аймгийн тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Номгоноос Өлзийтмандал хүртэлх автозам, явган хүний замын засвар, гэрэлтүүлэг, далан шуудууны тохижилт”-ын ажлыг 496,612,328 (дөрвөн зуун ерэн зургаан сая зургаан зуун арван хоёр мянга гурван зуун хорин найм) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналаар “Баянцогт зам” ХХК-тай 496,612,328 (дөрвөн зуун ерэн зургаан сая зургаан зуун арван хоёр мянга гурван зуун хорин найм) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Баянцогт зам” ХХК-ийн захирал (Б.Эрдэнэцогт)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

И. Доржбат

Л. ДОРЖБАТ

311150343